



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/462

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цагдаагийн байгууллагын түүхт 98 жилийн ойг тохиолдуулан Ард иргэдийнхээ амгалан, тайван амьдрах орчин бүрдүүлэх, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулан хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажиллаж буй Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Дэмчиг, Замын цагдаагийн тасгийн зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Э.Буянтогтох, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн харуулын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ч.Лхамаа нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Б.Дэмчиг, Э.Буянтогтох, Ч.Лхамаа нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа /Б.Батзаяа/-д зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

